

ЭНТРЕПРЕНЕР ИХ СУРГУУЛЬ: ПРОФЕССОР БАГШИЙН ЭНТРЕПРЕНЕР БОЛОХ ЗОРИЛГОД НӨЛӨӨЛӨХ ХУЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Д.Батцэцэг*, Н.Батдэлгэр**

Хураангуй: Академик энтрепренершипыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагын улмаас байгууллагын гишүүдэд энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэх, энтрепренер болох сэдлийг төрүүлэх нь нэн тэргүүний зорилт болохыг хүлээн зөвшөөрч, үүний төлөө их сургуулиуд маш их хүчин чармайлт гаргах болжээ. Энэхүү судалгаагаар сэтгэлзүйн болон байгууллагын стратегийн зорилтууд их сургуулийн багш нарын энтрепренер сэдэлд хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон. Судалгаанд МУ-ын төрийн өмчит 6-н их сургуулийн 274 профессор, багш оролцлоо. Судалгааны үр дүнд багш нарын энтрепренер болох зорилгод төлөвлөгдсөн зан төлвийн онолын хүчин зүйлс эерэг хамааралтай байсан. Мөн байгууллагын стратегийн зорилтууд шууд нөлөөлж байсан нь практик ач холбогдолтой байлаа.

Түлхүүр үгс: академик энтрепренершип, энтрепренер зорилго, стратегийн зорилт

ENTREPRENEURIAL UNIVERSITY: THE FACTORS INFLUENCING TO ENTREPRENEURIAL INTENTION OF THE UNIVERSITY'S FACULTY MEMBERS

Abstract: The need to develop academic entrepreneurship, which is recognized as a priority goal of the organization is cultivating entrepreneurial minds and intentions among the members. Regarding it, universities have been making an enormous effort to develop the entrepreneurial intentions of faculty members. The study examined psychological and contextual factors correlated to entrepreneurial intention in the academic environment. Based on 274 professors' survey responses from 6 different universities, our result shows that the factors determined by the theory of planned behavior directly correlated with entrepreneurial intention. The most important result was strategic objectives are associated with faculty members' entrepreneurial intentions.

Keywords: academic entrepreneurship, entrepreneurial intention, strategic goals

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): battseteg_d@num.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batdelger.n@num.edu.mn

Удиртгал

Их сургуулийн хөгжлийн чиг хандлага мэдлэгийг түгээн хөгжүүлдэг сургалт, судалгааны их сургуулиас мэдлэг бүтээж ашиглалтад оруулдаг энтрепренер их сургууль руу чиглэх болжээ. Учир нь их сургуульд бэлэн байгаа нөөц, чадавхи нь шинэ технологийг бий болгох хамгийн тохиромжтой газар бөгөөд энд бий болсон мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь улс орны хөгжлийн хурдасгуур болж байгааг MIT, Harvard, Stanford зэрэг их сургуулиудын жишгээр харж, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. Иймээс улс орнууд их сургуулиудынхаа бүс нутаг, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг өсгөхийн тулд академик энтрепренершипийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарах болжээ. Анх энтрепренершипийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийн тухай эдийн засгийн онолын эрдэмтэд танилцуулж байсан ба J.Schumpeter (1934) инноваци гэдэг бол нөөцүүдийн шинэ хослол бөгөөд инновацийн үйл явцтай мэдлэгийг нийцүүлэх нь энтрепренершипийн үндсэн үүрэг юм, (Rorke, 1998) ил болон далд мэдлэгийг практикт ашиглах нь эдийн засгийн өсөлтийн суурь болно гэдгийг тус тус тайлбарлаж энэхүү мэдлэгийг үйлдвэрлэгч их сургуулиудын энтрепренершипт оруулах хувь нэмэр их болохыг онцолсон байдаг.

Судлаачид их сургуулийн уламжлалт загвараас энтрепренер их сургуулийн загварт шилжих үндсэн шалтгаануудыг дурьдсан байдаг. Үүнд:

Их сургууль дээр хийгдэж буй шинэ нээлт, судалгааны үр дүн нь шинжлэх ухааны нэр хүндийг өсгөж байгаа хэдий ч аж үйлдвэрлэл болон эдийн засгийн салбарт оруулах хувь нэмэр бага байна (Rorke, 1998),

Их сургууль зөвхөн хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэн нийлүүлэх бус улс орон, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах нөөц, чадавхи бий (M. Guerrero, 2010) (2010), (H. Etzkowitz A. W., 2000,)

Их сургууль олон улсад өрсөлдөх чадвартай байхын тулд хөгжлийн чиг хандлагаа өөрчлөх зайлшгүй шаардлага байна (Rorke, 1998), (H. Etzkowitz, 2013) г.м

Мөн их сургууль энтрепренер чиг баримжаа бүхий хөгжлийн загварт шилжснээр шинжлэх ухаан, аж үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлж, улмаар нийгэм, эдийн засгийн үр ашиг хүртэх асар их боломж байдаг. Иймд 1/ их сургууль өөрөө энтрепренер болох, 2/ их сургуулийн багш, оюутнууд, ажилчид энтрепренер болох, 3/ их сургууль гадаад орчинтойгоо харилцахдаа энтрепренер замыг дагадаг байх хэрэгцээ шаардлага байгааг эрдэмтэн (Rorke, 1998) санал болгосон байдаг.

Энтрепренер их сургуулийн үүрэг, ач холбогдол

Шинэ мэдлэгийг боломж болгон хөгжүүлэх, мэдлэгийн хэрэглээг нэг байгууллагаас нөгөө байгууллага руу шилжүүлэх гэдэг нь тийм ч амар зүйл биш. Их сургуулийн профессор, эрдэмтэд өөрсдийн мэдлэг, туршлага дээр суурилан олон шинэ санаа, нээлтүүдийг хийсэн байдаг боловч тэдний ихэнх нь бүтээмжийг дээшлүүлэх, баялагийг нэмэгдүүлэх боломж болж чаддаггүй. Харин энтрепренерүүд боломжийг олж харж, шинэ санааг зах зээлийн хэрэглээнд нийцүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хувиргаж чаддаг. Тиймээс их сургуульд хийгдэж байгаа судалгааны үр дүн өндөр байх тусам үүнийг хэрэглээнд оруулах энтрепренершипыг улам бүр хөгжүүлэх хэрэгтэй (Рорке, 1998). Энтрепренершип бол өрсөлдөх чадвар, өсөлт хөгжлийн гол түлхүүр болохыг хүлээн зөвшөөрч их сургуулиуд дараах чиг үүргүүдийг хүлээх болжээ. Үүнд:

- Байгууллагын бүх гишүүдийн энтрепренер зорилго, зан төлөв, соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн алсын хараа, бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Нийгэмд ажлын байр бий болгох, шинэ бизнес эрхлэх мэдлэг, чадвартай энтрепренерүүдийг төрүүлэн гаргах, энтрепренершип боловсрол олгох
- Мэдлэгийг капиталжуулах, арилжаалах, технологийн инновацийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх
- Нийгэмд энтрепренершипын хөгжүүлэхэд манлайлах, оролцогч талуудтай хамтран ажиллахдаа энтрепренершип арга замыг мөрдөх
- Бүс нутаг, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах

Их сургууль энтрепренер их сургуулийн загвараар хөгжснөөр засаглалын хувьд бие даасан байх, санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох, үйл ажиллагааны хил хязгаараа тэлж илүү өргөн хүрээнд хөгжиж дэвших, олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, мэдлэгийн эдийн засагт оруулах хувь нэмрээ өсгөх гэх мэт олон талын ач холбогдолтой байна.


Онолын үндэслэл

Эрхэм зорилго нь төлөвлөлт, шийдвэр гаргалт, зохион байгуулалтын процессын чиг баримжаа болдог бөгөөд байгууллагын бүхий л түвшин дэх ажиллагчдын зорилгын биелэлт, үйл ажиллагааны удирдлага, чиг баримжаа болдог (Etzkowitz and Leydesdorff, 2000). Тиймээс их сургуулиуд энтрепренер чиг баримжаатай хөгжихийн тулд эрхэм зорилго, алсын хараагаа академик

энтрепренершиппийг хөгжүүлэхэд чиглүүлж үүндээ тохирсон хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдээ томъёолох шаардлагатайг олон судлаачид онцолсон байдаг. Их сургууль энтрепренер байх гол орцуудын нэг нь эрхэм зорилго байдаг (A. Salamzadeh, 2011). Энтрепренер алсын хараа, эрхэм зорилго бүхий байгууллагууд шинэ, инноваци бүхий бизнесийн боломжуудыг олж харах, ашиглах нөхцлийг бүрдүүлж бөгөөд их сургууль нь нийгэм, соёл, эдийн засаг хөгжилд нөлөөлөх гол тоглогч болохыг харуулж өгдөг ач холбогдолтой (Garcia, 2014). Энтрепренер их сургууль байхыг эрхэм зорилгоо болгосон их сургууль сургалт, судалгааг үйлдвэрлэлийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх (Etzkowitz, 2003), (Guerrero & Urbano, 2012), замаар академик энтрепренершиппийг хөгжүүлэх зорилтуудыг бөгөөд энтрепренершиппийг дэмжих дэд бүтэц болон удирдлага зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг хийдэг. Энэ нь гишүүдийн энтрепренер сэдэл (Huughe & Knockaert, 2015), академик энгэйжмэнтийг нэмэгдүүлэхэд (Zhao et al., 2020) хүчтэй нөлөөлдөг.

Судлаачид академик энтрепренершиппийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсд алсын хараа, эрхэм зорилго, зорилтууд, засаглал, бүтэц зохион байгуулалт, манлайлал болон соёлын элементүүдийг багтаан авч үздэг бөгөөд эдгээр хүчин зүйлсийн хэмжих, үнэлэх дэд үзүүлэлтүүдийг санал болгосон байдаг.

Зураг 1. Энтрепренер их сургуулийн хөгжилд нөлөөлөх дотоод хүчин зүйлс



Эх сурвалж: Судалгааны цр дүн

Эрхэм зорилгын стэйтментийг илэрхийлэх үзүүлэлтүүдэд: эрхэм зорилго, алсын харын хараа, стратегийн зорилтууд нь энтрепренершиппийг хөгжүүлэхэд чиглэсэн, тодорхой томъёологдсон, байгууллагын бүх гишүүд хүлээн зөвшөөрсөн байх (Harthy, 2014), (Maria, 2009), (M.Guerrero D. D., 2006), (Rasmussen, 2010), (A. Salamzadeh, 2011) (Allan Gibb, 2013), (Elza Alves Aranha, 2014), (Maria Jose Bezanilla, 2020). Мөн стратегийн хэрэгжилтийг хангах тодорхой бодлого, зохицуулалт, дүрэм, журмууд боловсронгуй байх (Rasmussen, 2010), (David A. Kirby, 2011), (Todorovic Z. W, 2011), (A. Salamzadeh, 2011), (Maria Jose Bezanilla, 2020);

Бүтэц ба засаглалыг илэрхийлэл дэд үзүүлэлтүүд: их сургууль мэргэжлийн менежментийн багтай байх (Harthy, 2014), (Maria, 2009), (M.Guerrero D. D., 2006), (Peter Schulte, 2007), энтрепренершипыг дэмжих удирдлагын дэмжлэг сайн байх (Carlos Eduardo L. Silva, 2018), (Donald F. Kuratko, 2014), (A. Salamzadeh, 2011), удирдлагын манлайлал хүчтэй байх (Maria Jose Bezanilla, 2020), (Harthy, 2014), (David A. Kirby, 2011), (OECD, 2012), удирдлага зохион байгуулалтын бүтцийн шатлал бага байх (M.Guerrero D. D., 2006), (Peter Schulte, 2007), (David A. Kirby, 2011), (Allan Gibb, 2013), доороос дээш (bottom-up) санаачлага гаргах системийг хөгжүүлэх, удирдлагын төвлөрөл бага байх (Maria, 2009), (David A. Kirby, 2011), (Harthy, 2014), (A. Salamzadeh, 2011);

Энтрепренер боловсролыг хэмжих үзүүлэлтүүдэд: их сургуульд салбар дундын хөтөлбөрүүдийг бий болгох, салбар дундын судалгааг хөгжүүлэх, байгууллагын бүхий л гишүүдэд энтрепренер боловсрол олгодог байх, энтрепренер сургалтын хөтөлбөр, курсуудыг нэмэгдүүлэх, сургалтын арга барилыг үйлдвэрлэл, бизнес, зах зээлд ойртуулан хөгжүүлэх (M.Guerrero D. D., 2006), (David A. Kirby, 2011), (Peter Schulte, 2007), (OECD, 2012), (Allan Gibb, 2013), (Elza Alves Aranha, 2014), (Maria Jose Bezanilla, 2020);

Энтрепренер соёлыг хэмжих үзүүлэлтүүдээр байгууллагын гишүүдийг шийдвэр гаргалтад оролцуулдаг байх, тэдэнд ажлаа хийх эрх чөлөө, бие даасан байдлыг хангах, энтрепренершип эвент, үйл ажиллагааг зохион байгуулах, урамшуулалын оновчтой системийг хэрэгжүүлэх болон гишүүдийн энтрепренершипт хандах хандлагыг нэмэгдүүлэх (M.Guerrero D. D., 2006), (David A. Kirby, 2011), (Peter Schulte, 2007), (Rasmussen, 2010), (OECD, 2012), (Allan Gibb, 2013), (Donald F. Kuratko, 2014), (Carlos Eduardo L. Silva, 2018) г.м үзүүлэлтүүдийг тус тус багтаан авч үздэг. Өмнөх судлаачдын дэвшүүлсэн дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэн үндсэн болон дэд үзүүлэлтүүдэд ангилан хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Энтрепренер их сургуулийг хөгжүүлэхэд нөлөөлөх дотоод орчны хүчин зүйлс

Үндсэн үзүүлэлтүүд			
Эрхэм зорилгын стэйтмент	Бүтэц, засаглал	Энтрепренер боловсрол	Энтрепренер соёл
Дэд үзүүлэлтүүд			
1. Эрхэм зорилго	1. Манлайлал	1. Салбар дундын хөтөлбөр	1. Бие даасан байдал

2. Алсын хараа	2. Мэргэжлийн менежмент	2. Салбар дундын судалгаа	2. Идэвхжүүлэлтийн үйл ажиллагаа
3. Стратегийн зорилтууд	3. Уян хатан бүтэц	3. Энтрепренер курсууд	3. Гишүүдийн хандлага, загвар дүр
4. Бодлого, зохицуулалтууд	4. Санхүүжилтийн бие даасан байдал	4. Сургалтын арга барил	4. Урамшуулалын систем

Эх сурвалж: Судалгааны цр дүн

Стратегийн зорилтуудыг төлөөлөх үзүүлэлтүүд

Энд дэвшүүлсэн 4 бүлэг 16 хүчин зүйлсээс бидний судлах боломжтой бүлэг болох эрхэм зорилгын стэйтмент, түүний 4-н дэд үзүүлэлтүүдийг сонгон авч МУ-ын төрийн өмчит 6-н их сургууль дээр шинжилгээ хийсэн. Эндээс их сургуулиудын эрхэм зорилго, алсын хараа энтрепренершипт чиглэсэн байгаа эсэхийг харахыг хүссэн. Харьцуулсан судалгаагаар их сургуулиуд эрхэм зорилго, алсын хараагаа энтрепренер сургууль болно гэж томъёолоогүй байсан. Харин стратегийн зорилтууд нь энтрепренершипыг хөгжүүлэхэд чиглэсэн байлаа. Тиймээс сонгож авсан сургуулиудын стратегийн төлөвлөгөөнд тусгасан зорилтуудад шинжилгээ хийхээр шийдвэр гаргасан. Шинжилгээ хийхдээ сургалт, судалгаа, энтрепренер байх гэсэн гурван чиг үүргийн хүрээнд энтрепренершипыг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байдлыг тодруулсан. Хүснэгт 2-г их сургуулиудын стратеги төлөвлөгөөнд хийсэн шинжилгээг харуулав.

Хүснэгт 2. Их сургуулиудын стратеги төлөвлөгөөнд
/стратегийн зорилтууд/ хийсэн шинжилгээ

№	Үндсэн чиг үүргүүд	Стратегийн зорилтууд	ИС-1	ИС-2	ИС-3	ИС-4	ИС-5	ИС-6
1	Сургалт	Салбар дундын хөтөлбөр бий болгох	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
2		Энтрепренер боловсрол олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх, хөгжүүлэх	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
3		Энтрепренер сургалтын арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм
4	Судалгаа	Хэрэглээний судалгааны үр дүнг сайжруулах	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
5		Салбар дундын судалгааг хөгжүүлэх	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм
6		Судалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Үгүй
7	Энтрепренер байх	Спин-офф, гарааны компаниудыг төрүүлэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
8		Энтрепренершикийг хөгжүүлэх дэд бүтцийг хөгжүүлэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
9		Санхүүжилтийн олон эх үүсвэр, тогтвортой байдлыг хангах	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
10		Нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
			6	4	8	9	6	8

Эх

сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх 10-н зорилтуудаас их сургуулиуд дээр ялгаатай байгаа 4-н зорилтыг сонгон авч, эдгээр зорилтууд энтрепренер сэдэлд шууд болон шууд бусаар хэрхэн нөлөөлж байгаад үргэлжлүүлэн шинжилгээ хийсэн.

Энтрепренер сэдэл нөлөөлөх сэтгэлзүйн хүчин зүйлс

Энтрепренер сэдэлд нөлөөлөх сэтгэлзүйн хүчин зүйлсийн нөлөөллийг судлаж буй судалгааны ажлууд ихэвчлэн (Ajzen, 1991) төлөвлөгдсөн зан төлвийн онол, (Sharero, 1982)-ийн энтрепренершип үйл ажиллагааны онол дээр суурилсан байдаг. Төлөвлөгдсөн зан төлвийн онолоор хувь хүний зан төлвийн гүйцэтгэлд тэдний зорилго (сэдэл) нөлөөлдөг бол зорилгыг өдөөх урьдач нөхцөл нь хандлага (attitudes to entrepreneurship), нийгмийн хэм хэмжээ (social norm), төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (perceived behavioral control) зэрэг болохыг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл өмнөө тавьсан зорилгоор нь хүний тодорхой зан төлвийн гүйцэтгэлийг таамаглах боломжтой бөгөөд тухайн зан төлвийг гүйцэтгэх хүсэл эрмэлмэл хэдий чинээ их байна, гүйцэтгэл төдий чинээ хүчтэй байдаг (Ajzen, 1991) байна. Бидний судалгаагаар МУ-ын их сургуулийн багш нарын энтрепренер байх зорилго, зорилгод нөлөөлөх хандлага, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ зэргийг тодруулахын тулд тодорхой таамаглалуулыг дэвшүүлж үр дүнг харахыг зорьсон.

Судалгааны загвар, асуулга боловсруулалт

Судалгааны загварыг боловсруулахдаа өмнөх судлаачдын загварт үндэслэн хөгжүүлсэн бөгөөд их сургуулийн стратегийн зорилтууд (SO) энтрепренер сэдэлд (EI) шууд болон шууд бусаар нөлөөнө. Шууд бусаар нөлөөлөхөд профессор багшийн энтрепренершипт хандах хандлага (ATE) болон зан төлвийн хяналт (PBC) дундын хүчин зүйл болно гэсэн таамаглалыг дэвшүүлсэн. Хөгжүүлсэн загварын дагуу шинжилгээ хийхдээ төрийн өмчит 6-н их сургуулийн 274 багшийн асуумжын хариултад үнэлгээ хийсэн.

Бие даасан хувьсагч

Стратегийн зорилтуудыг төлөөлөх хувьсагчуудыг өмнөх судлаачдын судалгааны ажлуудыг харьцуулан шинжилсний үр дүнд гаргаж ирсэн. Үүнд: 1/салбар дундын хөтөлбөрийг хөгжүүлэх, 2/ энтрепренер боловсрол олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, 3/энтрепренер сургалтын арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх, 4/нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн стратегийн зорилтууд багтана. Үүний дараа их сургуулиудын стратегийн төлөвлөгөөнд контент анализ хийж, dummy хувьсагч үүсгэснээр тоон болон чанарын аргыг хослуулан шинжилгээ хийсэн. Нийт 4 таамаглал дэвшүүлж, дэвшүүлсэн таамаглалуудаа шалгахын тулд судалгааны SPSS23 программ ашиглан үр дүнг нэгтгэв.


Зуучлагч хувьсагч

Сэтгэлзүйн хүчин зүйлсийг нөлөөлийг тодорхойлох асуултыг (M. Goethner, 2012), (Francisco Licbn), (Saeid Karimi H. J., 2017), (Virginia Fernandez-Rirez, 2014) (Stephen J. Franklin, 2001) нарын судалгааны асуулгыг ашиглаж Лайкертын 5 шкалаар үнэлүүлсэн (1=огт санал нийлэхгүй байна, 5= бүрэн санал нийлж байна).

Хянагч хувьсагч

Профессор багшийн энтрепренер сэдэлд оролцогчдын нас (5-интервал 1=20-29, 5=60-с дээш), хүйс (0=эрэгтэй, 1=эмэгтэй), албан тушаалын зэрэглэл (0= зөвлөх профессор, 5=дадлагачжигч багш), ажилласан жил (0=1-5 жил, 4=20-с дээш жил), бизнес эрхлэх магадлал (1=0%, 7=100%) зэргийг хянагч хувьсагчаар авч үзсэн бөгөөд SPSS, олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийж нөлөөлийн хүчийг хэмжсэн.

Зураг 2. Судалгааны загвар



Судалгааны таамаглал

Таамаглал 1. Стратегийн зорилтууд нь энтрепренер сэдэлд (EI) шууд нөлөөлнө.

Таамаглал 2. Энтрепренершипт хандах хандлага (ATE), энтрепренер сэдэлд (EI) шууд болон эерэгээр нөлөөлнө.

Таамаглал 3. Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (PVC) зэрэг нь энтрепренер сэдэлд (EI) шууд болон эерэгээр нөлөөлнө.

Таамаглал 4a. Стратегийн зорилтууд нь энтрепренер сэдэлд (EI) нөлөөлөх ба энтрепренершипт хандах хандлага (ATE) дундын хүчин зүйл болно

Таамаглал 4a. Стратегийн зорилтууд нь энтрепренер сэдэлд (EI) нөлөөлөх ба төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (PVC) дундын хүчин зүйл болно.

3. Судалгааны үр дүн

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ

Загварын дагуу дэвшүүлсэн таамаглалуудаа шалгахын тулд загварын нийцтэй байдал болон хувьсагчдыг илэрхийлж байгаа асуулгуудын төлөөлөх чадвар, найдвартай байдлыг тус тус үнэлсэн. Ингэхдээ хи квадрат 1-тэй ойр байх шалгуурыг тавьсан. Энтрепренер сэдлийг тодорхойлох дээрх бүлэг асуулгуудын хувьсагчуудаа төлөөлөх чадвар болон найдвартай байдал зэргийг шалгаж үзэхэд КМО шалгуурын үр дүн 0.886, бодит гүйцэтгэл 66.562% гарсан нь түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй байгааг, Бартлеттийн тестийн утга ($\text{sig}=0.000$) статистик ач холбогдолтой гарсан нь хүчин зүйлийн шинжилгээ үр дүнтэй болохыг илэрхийлж байна. Асуулгуудын найдвартай байдлыг илэрхийлэх Кронбах альфа коэффициент 0.7-с их гарсан (0.854) тул судалгааны асуулга оновчтой гэж дүгнэн, дараах 14 асуулгуудаар санал асуулга авч боловсруулалт хийх нь үндэслэлтэй бөгөөд найдвартай гэж үзлээ.

Хүснэгт 3. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ

		1	2	3
АТЕ2	Би гарааны бизнес эхлүүлвэл сэтгэл ханамжтай байх болно	0.838		
АТЕ3	Би гарааны бизнес эхлүүлэхдээ дуртай байх болно	0.757		
АТЕ1	Багш нар гарааны компани байгуулах нь сайн зүйл	0.663		
АТЕ5	ИС багш гарааны бизнес эрхэлж чадахуйц байх ёстой	0.658		
АТЕ4	Бизнес эрхлэгчид сонирхолтой санагддаг	0.629		
ЕИ1	Би гарааны компани байгуулахад бэлэн байна	0.579		
ЕИ2	Гарааны компани байгуулах арга замуудыг судлаж байна		0.819	
ЕИ3	Миний дараагийн карьерын зорилго компани байгуулах		0.774	
ЕИ4	Би ойрын ирээдүйд гарааны бизнес эхлүүлье гэж бодож байна		0.756	
ЕИ5	Гарааны компани байгуулах талаар нухацтай бодож үзсэн		0.743	
РВС3	Би шинэ бизнес санааг хэрхэн хөгжүүлэхийг сайн мэддэг			0.837

PBC2	Компани байгуулахад шаардлагатай мэдлэг, чадвар надад бий	0.825
PBC3	Компани удирдах надад хялбар байх болно	0.665
PBC4	Хэрэв би бизнес эрхлэвэл амжилт гаргаж чадна	0.522

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчид ба ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогчдын 25.6% нь профессор, 66.0% нь багш, 8,4% нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Эзэмшсэн мэргэжлийн тухайд бизнесийн удирдлага 20.4%, боловсрол 18.2%, инженер болон үйлдвэрлэл 27.0%, эрүүл мэнд 10.9% болон бусад салбарын мэргэжилтнүүд оролцсон. Насны бүлгээр авч үзвэл 30-39 насныхан 13.9%, 40-49 нас 39.8%, 50-иас дээш насныхан 46.4%, хүйсийн хувьд эрэгтэй 27.4%, эмэгтэй 72.6% байна. Дээд боловсролын салбарт ажилласан жил, туршлагыг авч үзвэл 1-10 жил ажилласан багш нар 22.7%, 11-20 жил ажилласан 45.2%, 20-с дээш жил ажилласан 32.1% гэсэн ерөнхий статистик гарсан.

Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээ

Хувьсагчдын хоорондын хамаарлыг шалгахын тулд хамаарлын шинжилгээ хийсэн. Бие даасан хувьсагчаар сонгон авсан стратегийн зорилтууд багш нарын энтрепренершипт хандах хандлага, зан төлвийн хяналт болон энтрепренер сэдэлтэй хэрхэн хамааралтай байгааг тодруулахын тулд хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээ хийсэн. Төлөвлөгдсөн зан төлвийн онол ёсоор энтрепренершипт хандах хандлага /ATE/ (.581, $p < 0.01$), зан төлвийн хяналт /PBC/ (.581, $p < 0.01$) зэрэг хувьсагчид энтрепренер сэдэлд эерэгээр нөлөөлж байсан. Стратегийн зорилтууд болох энтрепренер боловсролын хөтөлбөр (.121, $p < 0.05$), энтрепренер сургалтын арга барил (.121, $p < 0.05$) зэрэг хувьсагчид энтрепренер эерэг хамааралтай боловч ач холбогдлын түвшин багатай байлаа. Харин нийгмийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна гэсэн зорилтууд хувьд багш нарын энтрепренер сэдэлтэй хамааралгүй, энтрепренершипт хандах хандлагад сөрөг хамааралтай (-.131, $p < 0.05$) байсан. Хянагч хувьсагчид болох ажилласан жил, албан тушаалын зэрэглэл, нас, хүйсийн хувьд энтрепренер сэдэлтэй хамааралгүй байсан бол багш нарын бизнес эрхлэх магадлал өндөр байх нь энтрепренер сэдэлтэй сэдэлтэй эерэг бөгөөд хүчтэй (.554, $p < 0.05$) хамааралтай байсан. Мөн бизнес эрхлэх магадлал өндөр байх нь энтрепренершипт хандах хандлага болон зан төлвийн хяналтыг нэмэгдүүлдэг байна. Шаталсан регрессийн шинжилгээг хүснэгт 5- т харуулав.

Олон хүчин зүйлсийн шаталсан регрессийн шинжилгээ

Энтрепренер сэдэлд хувь хүний намтрын хүчин зүйлс (ажилласан туршлага, албан тушаалын зэрэглэл, нас, хүйс), сэтгэлзүйн хүчин зүйлс (энтрепренерт хандах хандлага, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт) болон байгууллагын стратегийн зорилтууд энтрепренер сэдэлд шууд болон шууд бусаар хэрхэн нөлөөлж байгааг шалгахын тулд олон хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Модель 1-р хянагч хувьсагчдын, модель 2-р бие даасан хувьсагчдын, модель 3-р дундын хувьсагчдын нөлөөллийг шалгасан. Ингэхдээ бүх загварын дисперсийн инфляцийн хүчин зүйлийг (VIFs) тооцоолох замаар хүчин зүйлсийн хооронд шугаман хамаарал байгаа эсэхийг шалгасан. Хоорондоо өндөр хамааралтай байгаа хувьсагч болох энтрепренер боловсрол олгох, энтрепренер сургалтын арга хэлбэрүүдийг ашиглах гэсэн зорилтуудаас сүүлийнхийг үзүүлэлтийг хасч тооцооллыг хийхэд үлдсэн хэмжүүрүүдийн хамгийн өндөр VIF нь 2.67 байсан бөгөөд энэ нь 5-аас бага утга (Hair et al. 2006) тул цааш судалгаа үргэлжлүүлэх боломжтой гэж үзсэн.

Модель 1-д ажилласан жил, албан тушаалын зэрэглэл, хүйс, нас, бизнес эрхлэх магадлал зэргийг нэг бүлэг болгон энтрепренер сэдэлд хэрхэн нөлөө үзүүлж байгааг шалгахад ач холбогдолтой байсан $R^2=.318$, $F(5,268)=24.912$, $p=.000$. Энэ моделийн үр дүнгээс профессор зэрэгтэй багшаас илүү залуу багш нар ($\beta=0.119$, $t=2.015$, $p<0.045$), мөн бизнес эрхлэх магадлал өсөх ($\beta=0.555$, $t=10.806$, $p<.001$) тусам энтрепренер сэдэл нэмэгдэж байгааг харж болно (хүснэгт 4). Харин ажилласан жил, нас, хүйсийн нөлөөлөл байсангүй. Модель 2-т өмнөх бүлэг хүчин зүйлс дээр нэмж стратегийн зорилтуудыг оруулан энтрепренер үзүүлэх нөлөөлөл байгаа эсэхд шинжилгээ хийхэд модел утга $R^2=.330$, $F(8,265)=16.323$, $p=.001$ ач холбогдолтой. Модель 3-т хянагч болон бие даасан хувьсагчид дээр нэмж дундын хувьсагчдыг оруулж шалгахад моделийн утга $R^2=.530$, $F(10, 263)=29.688$, $p=.001$ ач холбогдолтой гарсан. Энд энтрепренершипт хандах хандлага 36%, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт 26%-иар бие даасан хувьсагчид нөлөөлж байлаа. Дээрх шинжилгээний үр дүнд судалгааны хүрээнд дэвшүүлсэн **Н1** таамаглал хэсэгчлэн, **Н2** ба **Н3** таамаглал батлагдсан.

Хүснэгт 4. Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ

	Model 1	Model2	Model3
Constant	8.091	.899	.400
Хянагч хувьсагч			
Ажилласан жил	.031 (.416)	.039 (.523)	-.012 (-.194)
Албан тушаалын зэрэглэл	.119* (2.015)	.126** (2.074)	.087 (1.695)
Хүйс	-.001 (.979)	.014 (.248)	-.020 (-.426)
Нас	.021 (256)	.001 (.017)	.008 (-.115)
Бизнес эрхлэх төлөвлөгөө	.555*** (10.806)	.554*** (10.753)	.311*** (6.231)
Бие даасан хувьсагч			
Салбар дундын хөтөлбөр		.027 (.516)	.016 (.351)
Энтрепренер боловсрол олгох хөтөлбөр		.086* (1.725)	.068 (1.407)
Нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах		.024 (.415)	.069 (1.409)
Дундын хувьсагч			
ATE_1			.321*** (5.94)
PBC_1			.260*** (4.537)
F статистик	24.992	16.323	29.688
R ²	.318	.330	.530
Adjusted R ²	.305	.310	.512
R change	.318	.112	.200

Бие даасан хувьсагч- Энтрепренер сэдэл EI
Хүснэгтэд стандарчлагдсан бэта болон t-ийн утгуудыг харуулав.

*** $p < 0.00$, ** $p < 0.05$, * $p < 0.10$.

Шууд бус нөлөөллийн шинжилгээ

Дундын /зуучлагч/ хувьсагчын нөлөөлийг шалгахдаа Frazier, P. A, (2004) аргад үндэслэн шинжилгээ хийсэн. Ингэхдээ 1/бие даасан хувьсагч → зуучлагч хувьсагч, 2/ зуучлагч хувьсагч → хараат хувьсагч, 3/бие даасан хувьсагч → зуучлагч хувьсагч → хараат хувьсагчид хоорондоо ач холбогдолтойгоор хамааралтай байхыг шинжилж, 4/ 2 ба 3-р моделийн бета хувьсагчын харьцуулан 2>3-аас их байх нөхцлийг авч үзсэн. Ингээд таамаглал 4а болон 4b шалгахад: зорилт 3 буюу энтрепренер сургалтын арга хэлбэрийг ашиглах нь багшийн энтрепренершипт хандах хандлагыг нэмэгдүүлснээр энтрепренер сэдэлд нөлөөдөг нь батлагдсан. Харин төсөөлөгдсөн зан төлвийн хяналт зуучлалын нөлөөгүй байлаа. Ийнхүү таамаглал Н4а хэсэгчлэн батлагдаж, Н4b батлагдсангүй.

Хүснэгт 6. Шууд бус нөлөөллийн шинжилгээ

		St.Beta	t-value	Sig	
1	Зорилт1 →EI	.073	1.186	.237	Ач холбогдолгүй
	АТЕ →EI	.587	11.742	.001	
	Зорилт1 →АТЕ → EI	-.034	-.697	.488	
2	Зорилт2 →АТЕ	.127	1.844	0.61	Ач холбогдолтой
	АТЕ →EI	.578	11.768	.001	
	Зорилт2 →АТЕ → EI	.100	2.032	.043	
3	Зорилт4 →АТЕ	-.192	-2.858	.005	Ач холбогдолгүй
	АТЕ →EI	.592	11.930	.001	
	Зорилт4 →АТЕ → EI	.081	1.627	.105	
4	Зорилт1 →PBC	-.038	-.622	.534	
	PBC →EI	.583	11.773	.001	
	Зорилт1 →PBC → EI	.019	.392	.696	
5	Зорилт2→PBC	.056	.817	.414	Ач холбогдолгүй
	PBC →EI	.579	11.817	.029	
	Зорилт2 →PBC → EI	.108	2.200	.029	
6	Зорилт4 →PBC	-.088	-1.299	.195	Ач холбогдолгүй
	PBC →EI	0.584	11.814	.001	
	Зорилт4→PBC → EI	.043	.877	.381	

Хасагдсан үзүүлэлт: Энтрепренер боловсрол олгох- Зорилт 3

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар байгууллагын стратегийн зорилтууд болон энтрепренер сэдлийг хооронд зуучлагч хувьсагчаар төлөвлөгдсөн зан төлвийн онолын хувьсагчдыг (АТЕ, РВС) авч үзсэн. Өмнөх судлаачдын судалгааны ажлуудын үр дүнд шинжилгээ хийсний үндсэн дээр энтрепренер сэдэлд сэдэлд хамгийн хүчтэй нөлөөлдөг стратегийн 4-н зорилтыг сонгон авч шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулбал:

1. Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээгээр их сургуулиудын стратегийн зорилтууд болох “энтрепренер боловсрол олгох хөтөлбөр”, “энтрепренер сургалтын арга барил” зэрэг нь энтрепренер болох сэдэлд шууд нөлөөлж байсан. Эндээс сургалтын зорилтуудыг энтрепренершипт чиглүүлж тэдгээрийг байгууллагын гишүүдэд ойлгуулах, үүнтэй холбоотой процедурын өөрчлөлт шинэчлэл хийх нь энтрепренер болох сэдлийг нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэсэн.

3. Салбар дундын хөтөлбөрийг хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн стратегийн зорилтууд нь академик энтрепренершипт төдийлөн нөлөөтэй бус харагдсан. Үүнийг ямар нэг ач холбогдол байхгүй гэж шууд дүгнэж болох ч нөгөө талаас их сургуулийн гишүүдэд энэ зорилт хир ойлгомжтой, гүйцэтгэлтэй хэрхэн уялдсан байгаагаар илүү нарийн тайлбарлагдах боломжтой.

4. Их сургуулийн стратегийн зорилтын нэг болох энтрепренер хөтөлбөрийн хэрэгжүүлэх нь багшийн энтрепренершипт хандах хандлагыг нэмэгдүүлснээр тэдний энтрепренер сэдэлд нөлөөлж байгаа нь цаашид энтрепренер сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын арга хэлбэрүүдийг ашиглах нь үр дүнтэй гэж дүгнэлээ.

Энэхүү судалгааны ажил нь их сургуулийн стратегийн зорилгуудад шинжилгээ хийж, түүн дотроос академик энтрепренершипыг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтууд нь багш нарын энтрепренер сэдэлд хэрхэн нөлөөлж байгааг судласан давуу талтай. Цаашид их сургуулийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, дэмжлэг, идэвхжүүлэлтийн хүчин зүйлсийг профессор багшийн сэдэлд хэрхэн нөлөөлж буйн судлах шаардлагатай байна.

Ашигласан материал

- A. Salamzadeh. (2011). Towards a Systematic Framework for an Entrepreneurial University: A Study in Iranian Context with an IPOO Model,. *Global Business and Management Research: An International Journal*, 30-37.
- A. Salamzadeh, e. (2011). Towards a Systematic Framework for an Entrepreneurial University: A Study in Iranian Context with an IPOO Model, . *Global Business and Management Research: An International Journal*, 30-37.
- Ajzen, I. (1991). The theory of planned behavior. *Organizational behavior and Human Decision Processes.*, 50(2), 179-211.
- Allan Gibb, H. a. (2013). Leading the Entrepreneurial University: Meeting the Entrepreneurial Development Needs of Higher Education Institutions . *Universities in Change, Innovation, echnology, and Knowledge Management*, DOI: 10.1007/978-1-4614-4590-6_2., 9-45.
- Carlos Eduardo L. Silva, F. d. (2018). Concept and Criteria for the Characterization of the Entrepreneurial University: A systematic Literature review, . *Journal of Economics, Business and Management*, Vol. 6, No. 3, doi: 10.18178/joebm.2018.6.3.552, 65-71.
- Clark, B. R. (1998). Creating entrepreneurial universities: organizational pathways of transformation. . *Issues in higher education*. New York: Elsevier.
- David A. Kirby, M. G. (2011). Making Universities more Entrepreneurial: Develeopment of a Model, .
- Donald F. Kuratko, e. a. (2014). Diagnosing a firm’s internal environment for corporate entrepreneurship, . *Business Horizons* 57., 37-47.
- Elza Alves Aranha, e. (2014). Dimension of a metamodel of an entrepreneurial university,. *African Journal of Business Management*, Vol 8(10), DOI:10.5897/AJBM2013.7101, ISSN 1993-8233, 336-349.
- Etzkowitz, H. (1983). Entrepreneurial Scientists and Entrepreneurial Universities in American Academic Science. *Minerva*, Vol. 21, No. 2/3, 198-233.
- Etzkowitz, H. (2003). Research groups as ‘quasi-firms’: the invention of the entrepreneurial university. *Research Policy* 32, 109-121.
- G.Subotzky. (1999). Alternatives to the entrepreneurial university: New modes of knowledge production in community service programs. *Higher*

- Education*, Vol 38, 401-404.
- Garcia, E. A. (2014). "Dimensions of a metamodel of an entrepreneurial university". *African Journal of Business Management*.
- H. Etzkowitz. (2003,). Research groups as 'quasi-firms': the invention of the entrepreneurial university, . *Research Policy* 32, , 109-121.
- H. Etzkowitz. (2013). Anatomy of the entrepreneurial university. *Social Science Information* 52(3), 486-511.
- H. Etzkowitz, A. W. (2000,). The future of the University and university of the future: Evolution of ivory tower to entrepreneurial paradigm,. *Research policy* 29, 313-330.
- Harthy, S. H. (2014). Entrepreneurial University And The Entrepreneurial Environment: Organizational Analysis And Policy Consideration. *A thesis submitted to The University of Manchester for the degree of Doctor of Philosophy in the Faculty of Humanities*.
- Kirby, D. A. (2006). Creating entrepreneurial universities in the UK: Applying entrepreneurship theory to practice. . *Journal of Technology Transfer*.
- Kuratko, D. e. (2014). Diagnosing a firm's internal environment for corporate entrepreneurship, .
- M. Guerrero. (2010). The development of an entrepreneurial university. . *Journal of Technology Transfer*.
- M. Jacob, e. a. (2003). Entrepreneurial transformations in the Swedish University system: the case of Chalmers University of Technology. *Research Policy*, Volume 32, Issue 9, 1555-1568.
- M.Guerrero, D. D. (2006). A Literature review on entrepreneurial universities: An institutional approach, . *Universitat Autnoma de Barcelona. Departament d'Economia de l'Empresa*.
- M.Guerrero, D. D. (2006). A Literature review on entrepreneurial universities: An institutional approach, . *Universitat Autnoma de Barcelona. Departament d'Economia de l'Empresa*.
- Maria Jose Bezanilla. (2020). Developing the Entrepreneurial University: Factors of Influence, . *Sustainability*, 12, 842; DOI:10.3390/su12030842, 3-19.
- Maria, B. (2009). Entrepreneurial University in the Development of "Innovative regions". *Tomas Bata University in ZLin, Faculty of Management and Economics*.

- OECD. (2012). A Guiding Framework for Entrepreneurial Universities, .
- Peter Schulte. (2007). The entrepreneurial university: a strategy for institutional development, . *Higher Education in Europe, Volume 29*, DOI10.1080/0379772042000234811, 187-191.
- Rasmussen, E. (2010). University capabilities in facilitating entrepreneurship: A longitudinal study of spin-off ventures at mid-range universities, . *Research Policy 39* , 602–612.
- Ropke, J. (1998). The Entrepreneurial university: Innovation, academic knowledge creation and regional development in a globalized economy.
- Shapiro, A. (1982). Social dimensions of entrepreneurship. In Kent, C. , Sexton, D. , & Vesper, K. (Eds.), *The encyclopedia of entrepreneurship*. Englewood Cliffs, NY: Prentice Hall., 72–90.
- Todorovic Z. W. (2011). ENTRE-U: An entrepreneurial orientation scale for universities. *Technovation 31* , 128–137, doi:10.1016/j.technovation.2010.10.009.